



**БАЯНХОНГОР ҮЙЛДВЭРЖИЛТ
ХӨГЖЛИЙН КОРПОРАЦИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ**

2024 оны 01 сарын 02 өдөр

Дугаар 01

Номгон

Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци
ХХК-ийн 2024 оны бизнес төлөвлөгөө, бүтэц
орон тоо, албан тушаал, цалингийн санг
батлах тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.1 дэх, 80 дугаар зүйлийн 80.2 дахь, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2017 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн 04 дүгээр тогтоолоор батлагдсан “Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци” ХХК-ний Төлөөлөн удирдах зөвлөлийн ажиллах журам”-ын 2 дугаар зүйлийн 2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци” ХХК-ний 2024 оны бизнес төлөвлөгөөг нэгдүгээр, бүтэц орон тоог хоёрдугаар, албан тушаал цалингийн санг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Компанийн үндсэн үйл ажиллагаа, чиг үүргийн дагуу бизнес төлөвлөгөөний зорилт, ажил арга хэмжээний хэрэгжилтийг ханган төлөвлөгөөний тайланг хагас, бүтэн жилээр Төлөөлөн удирдах зөвлөлд тайлагнан, үр дүнг тооцуулах, батлагдсан бүтэц орон тоо, албан тушаал цалингийн сангийн дагуу ажилчдын албан тушаалын чиг үүрэг, үндсэн цалинг тогтоож, ажилтан албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтыг баталгаажуулан удирдлагаар ханган ажиллахыг гүйцэтгэх захирал (Б.Наранбаяр)-д үүрэг болгосугай.

3. Компанийн 2024 оны бизнес төлөвлөгөөнд батлагдсан төсөв санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулж, ажиллахыг гүйцэтгэх захирал (Б.Наранбаяр)-д зөвшөөрсүгэй.

4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга (Н.Одончимэг)-д даалгасугай.

ДАРГА

Ц.ОТГОНБАЯР

642205018